


Swiss Agency for Development and Cooperation SDC  
Швейцарын хөгжлийн агентлаг



# “ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЭ”

сарын аян



ХАЙРАА ХАЙРЛАЯ, ХАНДЛАГАА ӨӨРЧИЛЬЕ, ХАМТДАА ҮЛГЭРЛЭЕ



# АЯНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Аяны хугацаанд ямар ажлууд хийгдэх вэ?

# ТӨЛӨВЛӨГӨӨ



01

## MNB Хайрлаарай нэвтрүүлэг

МУОНТелевизтэй хамтран “Хайрлаарай” нэвтрүүлгийн уран бүтээлчдээр “Хүндлэл дүүрэн гэр бүл” сэдвийн хүрээнд танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэх. 2022.03.08, 2022.03.18-ны орой тус тус цацагдана.

02

## Үндэсний хэмжээний цахим хэлэлцүүлэг

“Эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөж буй тодорхой асуудлаар” үндэсний хэмжээний цахим хэлэлцүүлэг зохион байгуулах. 2022.03.04-ны өдөр зүүм платформоор.

03

## Eagle телевиз хэлэлцүүлэг

Ийгл телевизтэй хамтран “Эрэгтэйчүүдийн манлайлал, тулгамдаж буй тодорхой асуудал” телевизийн хэлэлцүүлэг зохион байгуулах. 2022.03.17-ны орой цацагдана.

04

## Нийгмийн сүлжээнд нөлөөллийн ажил өрнүүлэх

Эрэгтэй, эмэгтэйчүүдэд эерэг зан үйл, хандлагыг сурталчилж, уриалах. 4 төрлийн цахим постер. 2 төрлийн шторк. Нэмэлт 2 баннер boost хийнэ. 3 дугаар сарын турш.



# ТӨЛӨВЛӨГӨӨ

05



## ПОДКАСТУУДАД ОРОЛЦОХ

1. MGL радио 88.3 подкаст  
2. Ийгл Радио 91.1- Eagle.mn Uyanga's podcast гэх мэт дээрх сошиал 2 сувгаар дамжуулан подкаст хийлгэж цацах. Улмаар аянд олон нийтийг уриална.

2022.03.05 MGL radio  
2022.03.17 Eagle radio

06



## ЯАМД, ИТХ, ЗДТГ-УУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

ЖҮХ-ны Салбар зөвлөл, Салбар хороо бүр аянд нэгдэж, аяны хүрээг тэлж, идэвхжүүлэх ажил зохион байгуулах тухай чиглэл хүргүүлж, хамтран ажиллах.  
2022.02.17-ны өдөр 03/31 тоот албан бичиг хүргэгдсэн.  
2022.02.25-ны өдөр цахим уулзалт зохион байгуулна.

07



## АЯНЫ СУРТАЛЧИЛГАА

Аяны тухай мэдээ, мэдээллээр хангах, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах.

2022.02.28-ны өдөр цахим хэвлэлийн бага хурал зохион байгуулна.

08



## БУСАД

1. Нэмэлт баннерууд boost хийх ажил.  
2. Нэмэлтээр санхүүжүүлэгч байгууллагын ярилцлага.



# 1. ХАЙРЛААРАЙ НЭВТРҮҮЛЭГ

60 минутын нэвтрүүлгийн агуулга

Нас насны төлөөлөл бүхий үлгэр жишээ 3 гэр бүлийг оролцуулж, сэтгэл зүйчтэй хамтран бодит кейс ярилцаж, жендэрийн мэдрэмжтэй харилцан хүндлэл нь жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийн суурь шалтгааныг шийдэж болох тухай агуулгатай байна.



**ЗОЧИН ХӨТЛӨГЧ:**

**СЭТГЭЛ ЗАСЛЫН ЭМЧ  
Р.ЭНХТҮВШИН ОРОЛЦОНО.**

**ЗОЧИД:**

**Залуу гэр бүлийн төлөөлөл:**

Нөхөр: Энхбаярын Баярбат “Snog Frozen Yoghurt” тараган зайрмагны дотоодын франчайз үйлдэрлэл эрхэлдэг.

Эхнэр: Чадраабалын Ган-Инж “Амин Инж” ХХК-ийн гүйцэтгэх захирал, “INJ studio”-ын стилист, дасгалжуулагч багш, Ам бүл: 4.

Бага насны хоёр охинтой.

**Дунд насны гэр бүлийн төлөөлөл:**

Нөхөр: Д.Ганхуяг “Эрдэнэс газ” төслийн дэд захирал.

Эхнэр: Д.Болорцэцэг “Егүзэр хутагт” төвийн гүйцэтгэх захирал. 6 хүүхэдтэй.

**Ахмад насны гэр бүлийн төлөөлөл:**

МУГЖ Алтангэрэл, МУГЖ Энхтуяа нар байна.

## 2. “Эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөж буй тодорхой асуудлаар” үндэсний хэмжээний цахим хэлэлцүүлэг



04

**Б.БОЛОРСАЙХАН**

Хүний эрх  
хамгаалагч, Стратеги  
академийн захирал



05

**Х.МӨНХЗУЛ**


ХЭҮК-ийн  
гишүүн



01

**Т.ЭНХБАЯР**


ЖҮХ-ны Нарийн  
бичгийн дарга  
бөгөөд Ажлын  
албаны дарга



02

**Б.ОЮУН**

НҮБХАС-ийн  
Жендэрийн тэгш  
байдал, эмэгтэйчүүдийг  
чадавхжуулах  
хөтөлбөрийн  
мэргэжилтэн



03

**Д.СҮНЖИД**

ХЭҮК-ийн  
гишүүн





Цахим хэлэлцүүлгийн чиглүүлэгч,  
сэтгүүлч Э.Энэрэл ажиллана.



## ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН СЭДЭВ:

1. **Нийгмийн сүлжээнд охид, эмэгтэйчүүд рүү чиглэсэн ялгаварлан гадуурхалт**
2. **Эсэн мэнд амаржихуй, эхэд үзүүлж буй олон талт туслалцаа, дэмжлэг**
3. **Салбартаа манлайлагч эмэгтэйчүүдийн алдаршуулалт**



**Токарийн багш  
Д.Туул**

1976 оноос хойш токарийн мэргэжлээр ажиллаж, 1986 оноос хойш Налайх МСҮТ-эд багшлаж байгаа. Инженерчлэлийн салбарын манлайлагч эмэгтэйг цахим хэлэлцүүлэгт оролцогчдод алдаршуулан танилцуулна.



**Сувилагч  
Т.Ариунаа**

1996 оноос хойш 1-р уушги, төвийн сувилагчаар ажиллаж байгаа, эрүүл мэндийн салбарын манлайлагч сувилагчийг алдаршуулан танилцуулна.



**Алтан төлийн эзэн  
Д.Дулмаа**

МҮОНРадиоогийн санаачилгаар 44 дэх жилдээ зохион байгуулагдаж байгаа алтан төлийн эзэн тодруулах үйл ажиллагаанд энэ жилээс эмэгтэйчүүдийг шалгаруулж эхэлсэн тухай.



### 3. “Эрэгтэйчүүдийн манлайлал, тулгамдаж буй тодорхой асуудал”

#### 60 минутын телевизийн хэлэлцүүлгийн агуулга, хэлбэр

Эрэгтэйчүүдийн эерэг хандлагаар чухалчлан ярих 2 эрэгтэй зочин, тулгамдаж буй асуудлуудаар ярих 2 эрэгтэй зочин. Нийт 4 зочин оролцож, телевизийн хөтлөгч болон Ажлын албаны дарга Т.Энхбаяр зочин хөтлөгч буюу чиглүүлэлт хийсэн хэлэлцүүлэг байна.

Эрэгтэйчүүдийн ноён нуруу, жудаг, ёс зүйн хүндэтгэлт чанар ба өнөөгийн монголын нийгэмд эрэгтэйчүүдийн өмнө тулгамдаж буй тодорхой асуудлаар асуудал дэвшүүлэх замаар олон нийтийн анхаарлыг хандуулах, эрэгтэйчүүдэд хортойгоор нөлөөлж буй эрэгтэйлэг хэв шинж буюу маскулинити ойлголтыг өөрчлөх, жендэрийн хэвшмэл ойлголтоос ангижрах.

#### Хэлэлцүүлгийн зочид:

- Гэр бүл судлаач Н.Амарсанаа (Гэр бүл дэх эрэгтэйчүүдийн оролцоо, онцлог анхаарах асуудал, Гэр бүлийн зөвлөгөө зөвлөмж өгөх.)
- Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Урологи-Андрологийн төвийн их эмч П.Мягмарсүрэн (Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам)
- МУАЖ Г.Мягмарнаран (Монгол эр хүний ноён нуруу, эр хүн гэж хэнийг хэлэх вэ?)
- Өрх толгойлсон аав К.Эрдэнэбат (3 хүүхэдтэй. 22, 20, 18 настай. 2 охин 1 хүүтэй. Мужаан мэргэжилтэй. Барилгын салбарт ажилладаг. Өрх толгойлсон аавуудад тохиолддог хүндрэл бэрхшээл)





# 4. Нийгмийн сүлжээнд нөлөөллийн ажил өрнүүлэх. 3 дугаар сарын турш

## 4 ТӨРЛИЙН ЦАХИМ ПОСТЕР BOOST ХИЙНЭ.

**Эмэгтэйчүүдэд чиглэсэн агуулга нь:**

-Нөхөр минь ганцаараа мөнгө олох ёстой биш. Би ч гэсэн нэмэр оруулж чадна.

-Нөхөр минь зөвхөн хүчирхийлэл үйлдэгч биш. Би ч гэсэн уур бухимдал, зохимжгүй үгэндээ анхаарах ёстой.

**Эрэгтэйчүүдэд чиглэсэн агуулга нь:**

-Эхнэр минь заавал гэрийн ажилд нухлагдах албатай биш. Би ч гэсэн хийж чадна.

-Эхнэр минь миний санхүү, үзэл бодолд захирагдах албагүй. Тэр минь өөрийн цалин орлоготой, нийгэмд байр сууриа олж ажиллаж амьдрах эрхтэй.



## 2 ТӨРЛИЙН ШТОРК BOOST ХИЙНЭ.

1. Гэр бүлийн хосуудад түгээмэл ажиглагддаг харилцаа, хандлагын хэвшмэл ойлголтын эсрэг залуу гэр бүл хэрхэн дуугарч байгаа тухай агуулгатай шторк байна. Постеруудын агуулга шингэсэн өнгө аястай байна.
2. Ийгл телевизийн хэлэлцүүлгээр хөндөгдөх эрэгтэйчүүдийн дундаж наслалт, үндэсний хэмжээний цахим хэлэлцүүлгээр хөндөгдөх эх нярайн эндэгдэлийн агуулгаар мэргэжлийн эмч нар уриалга дэвшүүлсэн агуулга өнгө аястай байна.



ОЛОН НИЙТЭД ЭЭРЭГ ХАНДЛАГЫГ СУРТАЛЧИЛАХ




ТУЛГАМДСАН АСУУДАЛД АНХААРАЛ ХАНДУУЛАХАД ЧИГЛҮҮЛЭХ




ОЙЛГОЛТ, МЭДЛЭГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ





### ХҮРТЭЭМЖ

- 46% : 345.000
- 31% : 145.000
- 14% : 75.000
- 9% : 71.000



ТА БҮХЭН УГ ШТОРК,  
ЦАХИМ ПОСТЕРИЙГ  
АЛЬ БОЛОХ ХҮН ХҮНД  
ДАМЖУУЛЖ, ШЭЙР  
ХИЙХИЙГ  
ЭРХЭМЛЭНЭ ҮҮ.

# 5. MGL radio 88.3 podcast



Дэлхий даяар 682,373  
байнгын сонсогчтой.

Зочны цаг нэвтрүүлгээр подкастад оролцож, радио өргөн нэвтрүүлэг цацагдахаас гадна сошиал сувгаар давхар бичлэг цацагдана.

2022.03.05-ны өдөр 17:30 цагт цацагдана.


Сэдэв нь доорх 2 сэдвийн хүрээнд яриа өгч, олон нийтийг аянд уриална.

- ◆ Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо
- ◆ Жендэрийн мэдрэмжтэй ажлын байр төлөвлөлт
- ◆ Б.Золзаяа Өөрчлөлтийн төлөөх ТББ
- ◆ Б.Болорсайхан Стратеги академийн захирал



# 5. Ийгл Радио 91.1-Eagle.mn Uyanga's podcast

EAGLE  
news tv



Хандлагаа  
вөрчилъе

Хамтдаа  
үлгэрлэе

Харилцан  
Хүндэтгэе

Хайраа  
хайрлая



Ийгл телевизийн хүүхэд эмэгтэйчүүд эсрэг хүчирхийлэл, хүний эрх, жендэрийн чиглэлээр мэдээ, сурвалжлагаар дагнан ажилладаг сэтгүүлч А.Уянгатай хамтран **Uyanga's podcast** хийхээр төлөвлөсөн. Түүний подкаст нь видео хэлбэрээр Сэтгүүлч Уянгын подкаст фэйсбүүк пэйж болон Uyanga's podcast youtube сувагт нийтлэгддэг. Мөн Ийгл радио 91.1-ээр цацагддаг. Тухайн долоо хоногтоо 3 удаа давтдаг. Мөн eagle.mn сайтын Подкаст, сонсдог нийтлэлүүд хэсэгт нийтлэгддэг.

2022.03.17-ны өдөр 17:30 цагт цацагдана.

Дараах сэдвийн хүрээнд яриа өгч, олон нийтийг аянд уриална.

- ◆ Эрэгтэйчүүдийн нийгэмд тулгамдаж буй асуудлууд, түүнийг шийдвэрлэх арга замуудын тухай
- ◆ Д.Батхишиг ЖҮХ-ны Ажлын албаны Эрэгтэйчүүдийн хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- ◆ Н.Амарсанаа Гэр бүл судлаач



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development  
and Cooperation SDC  
Швейцарийн хөгжлийн агентлаг

# Стефани Бурри MNV world сувгаар ярилцлага өгнө.

Сэдэв: Швейцарын хөгжлийн агентлагийн Монголд хэрэгжүүлж буй ажлууд. Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг ажлыг дэмжих, санхүүжүүлэхийн ач холбогдол. Энэ ажлын ололт амжилт, саад бэрхшээл, цаашдын алхам.



2022.03.14 эсвэл 21-нд  
цацагдана.





# Эрхээ тэгшээ 2 комик

## Сошиал нөлөөлөл

Хүүхдэд зориулсан жендэрийн хэвшмэл ойлголтоос ангид байх агуулга бүхий тус комик номыг нийгмийн сүлжээнд boost хийнэ.

## 10-18 насныханд зориулагдсан



Аль болох олон хүнд хүргэж, ажиллахыг та бүхнээс уриалж байна.

## Зөвөөр үлгэрлэе

Хүүхдүүдэд багаас нь ямар хандлага харилцаа буруу болох явал зөв болох тухай ойлголт өгч, хамтран ажиллая.

## Аяны хүрээнд нэмэлт агуулга

Та бүхэн өөр өөрийн албан байгууллага дээрээ хүүхдүүдэд чиглэсэн ажил зохион байгуулж болно. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр энэ чиглэлээр нийтлэл нэвтрүүлэг бэлтгэж болох юм.



# САЛБАР, ХОРООДЫН ЗҮГЭЭС АЯНД НЭГДЭН ОРОЛЦОХ ЧИГЛЭЛ, АРГАЧЛАЛ

## АЯНД НЭГДЭХ

Салбар, хороодын түвшинд аяны талаарх мэдээллийг түгээж, аянд нэгдэхэд уриалах, өөрсдөө нэгдэж буйгаа илэрхийлсэн уриа, орго орсон, зураг мэдээллийг оруулж, сэдэлжүүлэх дагуулах

## ХҮНДЛЭЛ ДҮҮРЭН ГЭР БҮЛ

Жендэрийн мэдрэмжтэй харилцан хүндлэлтэй байхад уриалсан үйл ажиллагааг зохион байгуулах

## ХАЙРАА ХАЙРЛАЯ-ХАМТДАА ҮЛГЭРЛЭЕ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Радио, ТВ, цахим, танхим хэлбэрээр хэлэлцүүлэг өрнүүлэх



## ОЙЛГОЁ-ХҮНДЛЭЕ


Өсвөр насныханд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг өрнүүлэх

## ҮНЭЛГЭЭ-ТАЙЛАН

Аяны үр дүнг үнэлэх



# АРГАЧЛАЛ



Аяны лого, уриа, цахим постер, мэдээ мэдээллийг олон сувгаар түгээх  
Цахим орчинд (фэйсбүүк, вэб, инстаграм, youtube, twitter, сайт)  
ОНМХ (телевиз, радио, сонин хэвлэл)  
Бусад (Гудамжны лед дэлгэц, хулдаасан самбар, байгууллагуудад урсдаг мэдээллийн самбар)  
(Батлагдсан лого, уриа, постерыг хүргэнэ)

Сценари гаргах (Ямар үйл ажиллагааг зохион байгуулах, хэнийг оролцуулах, хэнд зориулсан байх, ямар мэдээллийг олгох, ямар дүнг хүлээж байгаа)

Салбарын онцлог, ажил мэргэжлийн ялгаатай байдал, гэр бүлийн байдал, гишүүн бүрийн хүндлэл, хайр, хандлагыг илэрхийлэх  
Сэтгэл зүйч, багш, эмч, өвөө, эмээ, аав, ээж зэрэг олон талын төлөөллийг оролцуулах  
Зураг, дүрс, кэйс ашиглах  
Олны танил үлгэр дуурайлал болсон хүмүүсийг урьж оролцуулах

Эрхээ Тэгшээ комик агуулгын хүрээнд, Сургалт  
Өдөрлөг  
Үдэшлэг  
Аялал  
АХА тэмцээн  
Уралдаан

Аяны явцад зохион байгуулж буй үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг зураг, дүрстэй цаг тухай бүрт ирүүлэн, ЖҮХ-ны вэб болон фэйж хуудсаар олон нийтэд түгээх,

Нэгдсэн тайланг бүх салбар, хороод ирүүлэх 4 сарын 05



# АНХААРАХ АСУУДЛУУД:



- Аяны хүрээнд зөвхөн батлагдсан лого, уриаг ашиглана.
- ОНМХ-ээр өгөх мэдээллийн эх сурвалж нь үнэн бодитой, аяны агуулгаас гажихгүй, эерэг мессэжтэй байна.
- Хүний эрх, жендэр, жендэрт суурилсан хүчирхийлэл, ГБХ-ийн талаар мэдээлэл мэдлэг олгох, нийтлэл нэвтрүүлэг хийхдээ мэдрэмжтэй хандах,
- Аяны хугацаанд салбар зөвлөл, хороод санаачлагатай байж сарын турш аяныг дэмжих үйл ажиллагаагаа сулруулахгүй байх
- ХМБ-ууд болон сэтгүүлчдийг татан оролцуулахад онцгой анхаарч, тэдэнтэй хамтран арга хэмжээгээ өргөжүүлэх (мэдээлэл, арга зүйгээр хангах, сонирхол анхаарлыг татах мэдээ, мэдээлэл үйл ажиллагааг санал болгох)



# • ЗАРЛАЛ



ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРАЛД УРЬЖ БАЙНА.

2022.02.28-ны 11 цагт болох “ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЕ” аяны нээлтийн хэвлэлийн бага хуралд ХМБ-ын сэтгүүлчид та бүхнийг урьж байна.

Хурал цахимаар болно.

- Хурлын холбоос: Join Zoom Meeting
- <https://unfpa.zoom.us/j/81934053221>



# Анхаарал хандуулсанд баярлалаа.

Жендэрийн Үндэсний хороо